



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/179

Улаанбаатар хот

Г Тушаалын хавсралтад нэмэлт, Г  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны “Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Дэлхийн шилдэг сургуульд оюутан суралцуулах журам”, Засгийн газрын 2020 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Суралцаж буй сургуулийн тодорхойлолт, өргөдлийг харгалзан үзэж Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/454 тоот тушаалын хавсралт дахь Зоригтбаатар овогтой Намуундарь, 2016 оны 05 дугаар сарын 25-ны А/215 тоот тушаалын хавсралт дахь Эрдэнэбат овогтой Энхбилэг, Халиун овогтой Цэлмүүн, Энхбат овогтой Содбилэг, Мөнхбаяр овогтой Тамир, Мөнхөө овогтой Марал, Гандеш овогтой Анар-Эрдэнэ, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/392 тоот тушаалын хавсралт дахь Наран овогтой Баясгалан нарын гэрээг тус тус 1 жилээр сунган төгсгөсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/454 тоот тушаалын хавсралт дахь Батбаяр овогтой Тэмүүлэнгийн эрүүл мэндийн шалтгааны улмаас суралцаагүй 2 жилийг холбогдох эрүүл мэндийн байгууллагаас олгосон баримт бичгийг үндэслэн гэрээг 2 жилээр сунгасугай.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/391 тоот тушаалын хавсралт дахь Ганзориг овогтой Мишээлд “University of Oxford” 4 жил гэснийг “University College London” 4 жил гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/592 тоот тушаалын нэгдүгээр хавсралт дахь Халтар овогтой Булгантамирт холбогдох хэсгийн “University of Illinois at Chicago” 2 жил гэснийг “University of Columbia” 1 жил гэж тус тус өөрчилсүгэй.

4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/114 тоот тушаалын хавсралтад Од-Эрдэнэ овогтой Оюун “University of

142010697

Western Australia” 2 жил, Батбаатар овогтой Саранчимэг “University of Denver” 2 жил, Алтангэрэл овогтой Нарангаравуу “King’s College London” 1 жил гэж тус тус нэмсүгэй.

5. Суралцагчидтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /Ж.Ариунболд/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар /Д.Гарди/-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН